



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 21 өдөр

Дугаар A/08

Батноров сум

Газар эзэмшүүлэх эрх шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн хүсэлт гаргасны дагуу иргэн Намжилваанчиг овогтой Батбилэгийн Бэрх 7 дугаар багийн Дулаан гудамж 203 тоот хаягт байрлах ХАА-н үйлдвэрлэлийн цогцолборын зориулалттай 2304012168 нэгж талбарын дугаар бүхий 5600 квадрат метр газрын эзэмших эрхийг иргэн Сүхбаатар овогтой Чингэсд шилжүүлсүгэй.
2. Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, газрын тухай хууль болон гэрээнд заагдсан заалтуудын дагуу эзэмшихийг С.Чингэсд үүрэг болгосугай.
3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Т.Очирбат)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны А/152 дугаар захирамж болон 0000109588 тоот газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосугай.

ДАРГА



ОТГОНБАЯР

230425028